



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.18 № 02/12 ЧАГ-САГ/2014/НЗ1/СТГА-ТЦЗ

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ЖҮГДЭР ТАНАА**

Зөрчил арилгуулах тухай


Багахангай дүүргийн Нийгмийн Халамж Үйлчилгээний Хэлтсийн Халамжийн сангийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад иргэн Ч.Даваажавт 414400 төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэврийг илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т "Халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухайн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д заасан "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..." гэсэн заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

Илүү олгосон 414400 төгрөгийн халамжийн тэтгэврийг иргэн Ч.Даваажаваар төлүүлж, Төрийн банкны Багахангай салбарын 300500031445 тоот дансанд 2014 оны 4 дүгээр сарын 10-ны дотор буцаан төвлөрүүлэн биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Багахангай дүүргийн Нийгмийн Халамж Үйлчилгээний Хэлтсийн дарга Д.Жүгдэр, нягтлан бодогч О.Солонго нарт хариуцуулав.

Аудитор



Ш.Отгонбаяр